

ГАЗРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023.01.04

Дундговь аймаг

Тус аймгийн “Луус, Хулд, Өндөршил, Цагаандэлгэр, Баянжаргалан сумдын Газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх удирдамж”-ийг байгууллагын дарга 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр баталсан.

Удирдамжийн дагуу дээрх сумдын Газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, www.egazar.gov.mn хаягаар иргэдэд үйлчилгээ үзүүлж буй эсэх, цахим хаягийг сурталчилсан байдал зэрэгт хяналт шинжилгээ үнэлгээ хийж, зөвлөн туслах зорилгоор дээрх 5 сумын Газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулсан.

Газрын даамлуудын үйл ажиллагааны гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг агентлагаас баталсан шалгуур үзүүлэлттэй уялдуулан шинэчлэн боловсруулж шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэсэн. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ болон зөвлөмжийг Газрын даамлуудад тухай бүр танилцуулж, баталгаажуулсан.

Хяналт шалгалт хийсэн сумдын үнэлгээ:

Хулд сумын Газрын даамал 77.1 хувь

Луус сумын Газрын даамал 78.3 хувь

Өндөршил сумын Газрын даамал 81.4 хувь

Цагаандэлгэр сумын Газрын даамал 76.8 хувь

Баянжаргалан сумын Газрын даамал 81.8 хувьтай тус тус дүгнэгдсэн.

Дээрх 5 сумын Газрын даамлуудад өгсөн нийтлэг зөвлөмж:

- Хил залгаа, сумдын хилийн цэсийн маргаантай байгаа асуудлыг 2023 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган шийдвэрлэх
- Геодезийн цэг тэмдэгтийг нүд үзэн тоолох
- Сум суурин газарт хийгдсэн газар дээрх болон доорх шугам сүлжээний зургийг шалгаж хүлээн авч, гүйцэтгэлийн зургаар мэдээллийн сангийн шинэчлэлтийг серверт хандан хөтлөх
- Газар зүйн нэрийг ашиглах талаар олон нийтэд таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах
- Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний биелэлтийг вэб системд оруулж, тухайн жилийн ГЗБТ-нд тусгаж хэвших
- Өргөдөл хүсэлтийг цахимаар авах г.м зөвлөмжийг сумдын Газрын даамлуудыг өгсөн.

Сайхан-Овоо, Адаацаг сумдууд Газрын даамалгүй ба Дэрэн сумын Газрын даамал 2022 оны 10 дугаар сард томилогдсон тул дээрх 3 суманд хяналт шалгалт зохион байгуулаагүй.

Тус аймгийн 15 сумын Газрын даамлын газар олголтын үйл ажиллагаанд үйл ажиллагаанд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын 2022 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Газрын тухай, Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай, Геодези зураг зүйн тухай, Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуулиуд тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандарт, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж, эрсдэлээс урьдчилан сэргийлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зорилгоор аймгийн Мэргэжлийн хяналтын газраас урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн.

Аймгийн хэмжээнд сумдын Газрын даамлуудын үйл ажиллагаанд нийт 19 хяналт шалгалт хийж нийт 430 зөрчил илэрсэн байна.

Үүнд:

- 2 жил дараалан ашиглаагүй 46 нэгж талбарт мэдэгдэх хуудас хүргүүлж 20 нэгж талбарын газар эзэмших эрхийг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтын дагуу хүчингүй болгосон.
- Гэрээний заалт зөрчсөн буюу хэмжээнээс илүү газар эзэмшиж өмчилж байгаа, зориулалтын дагуу газар ашиглаагүй 6 иргэн, аж ахуй нэгжид мэдэгдэх хуудас хүргүүлсэн.
- Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан 295 нэгж талбарын газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгасан.
- Аймгийн хэмжээнд дур мэдэн автомашины гараж, контейнер, амбаар, ёмкость, дугуй засвар, хашаа, хавтан тавьж зохих зөвшөөрөлгүйгээр газар ашиглаж буй 93 иргэн, аж ахуй нэгжид газар чөлөөлөх мэдэгдэх хуудас хүргүүлэн 47 байршилд газрыг албадан чөлөөлөх ажлыг зохион байгуулж, газрыг бүрэн чөлөөлж, өмчлөлийн газрынхаа хэмжээг зохих зөвшөөрөлгүй сунгасан 20 нэгж талбарын хашааг татуулсан байна.

Хянасан:

ГАЗРЫН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА



Б.РЭНЦЭНДОРЖ

Тайлан гаргасан:

ГАЗРЫН ТӨЛБӨР, ҮНЭЛГЭЭ, ТАТВАРЫН
АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be 'Д.Болорчимэг'.

Д.БОЛОРЧИМЭГ